Сумын нэгтгэсэн санхүүгийн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Булган сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 онд санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 7,606.9 сая төгрөгөөс 1.5 хувиар тооцон 114.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 85.6 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган сумын ТТЗ-ын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,506.2 сая төгрөгөөр буюу 11 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр өмчийн дансдууд байна.

Хүснэгт №1. Санхүүгийн байдлын тайлан

/сая. төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Мөнгөн хөрөнгө	231.5	299.2	-67.7	129%
Авлага	686.1	567.2	118.9	83%

Бараа материал	336.9	356.2	-19.3	106%
Үндсэн хөрөнгө	11,926.2	13,464.3	-1,538.1	113%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	13,180.7	14,686.9	-1,506.2	111%
Богино хугацаат өр төлбөр	14.8	47.3	-32.5	320%
Цэвэр хөрөнгө, өмч	13,165.9	14,639.6	-1,473.7	111%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,180.7	14,686.9	83,525.2	111%

Эх сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 231.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 299.2 сая төгрөг болж 67.7 сая төгрөгөөр буюу 29 хувиар өссөн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 299.2 сая төгрөг нь Төрийн сангийн харилцах дансанд, Минжит Булган хот тохижилтын мөнгөн хөрөнгийн 29.1 мянган төгрөгийн үлдэгдэл арилжааны банкинд байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 686.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 567.3 сая төгрөг болж 118.7 сая төгрөг буюу 18.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 2: Авлагын үлдэгдэл

сая. Төгрөг

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	7.6	3.3	(4.3)
Байгууллагаас авах авлага	84.8	63.0	(21.8)
Хувь хүмүүсээс авах авлага	35.0	113.8	78.8
Зээл, зээлийн хүүгийн авлага	529.0	344.1	(184.9)
Татаас санхүүжилтийн авлага	14.6	17.1	2.5
Дүн	671.0	541.3	(129.7)
Урьдчилж гарсан зардал	15.0	-	(15.0)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа		26.0	26.0
Дүн	15.0	26.0	11.0
АВЛАГЫН НИЙТ ДҮН	686.0	567.3	(118.7)

Эх сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд 170.7 сая төгрөгийн насжилт өндөртэй байгаа авлагын дийлэнхийг сум хөгжүүлэх сангийн зээл 135.3 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлага эзэлж, оны эхэнд 548.2 мянган төгрөгийн зээлийн авлагын үлдэгдэлтэй байсан ба тайланд 243.0 сая төгрөгийн төлөгдөж 59.2 сая төгрөгийн зээл олгогдож оны эцэст 305.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй, малжуулах төсөл хөтөлбөрийн авлагын эхний үлдэгдэл 40.8 сая төгрөгөөс тайлант онд 5.4 сая төгрөгийн авлагыг барагдуулж 35.4 сая төгрөгийн үлдэгдэл нь насжилт өндөртэй хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл оны эхэнд 336.9 сая төгрөг, оны эцэст 356.3 сая төгрөгөөр болж 19.3 сая төгрөгөөр өссөн нь бичиг хэрэг, аж ахуйн материал, түлш, шатах тослох материалууд нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 512.4 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, үнэ төлбөргүйгээр 9,2 сая төгрөгөөр нийт 502.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 356.1 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 15,491.3 сая төгрөг байсан бол оны эцэст 17,669.9 сая төгрөг болж 2,178.6 сая төгрөгөөр өссөн нь 19.0 сая төгрөгийн

хөрөнгийг худалдан авсан, 2,332.1 сая төгрөгөөр хандив, үнэ төлбөргүй, шилжүүлэн авсан зэрэгтэй холбоотойгоор нэмэгдсэн нь тайлант онд УТХО-аар 1 дүгээр сургуулийн спорт заалны барилга шинээр баригдаж ашиглалтад орсон, 1 дүгээр цэцэрлэгийн барилгад их засвар хийгдсэн холбоотой байна .

Тайлант онд үндсэн хөрөнгө 2,351.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр үнэ төлбөргүй, хандив, шилжүүлэн авсан зэргээр нэмэгдэж, 117.3 сая төгрөгийн хөрөнгө акталж, 55.2 сая төгрөгөөр үндсэн хөрөнгийн ангилал хооронд шилжүүлсэн зэргээр хасагдсан байна.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 14.8 сая, оны эцсийн үлдэгдэл 47.3 сая төгрөг болж 32.5 сая төгрөгөөр өссөн, дараа тайлангийн хугацаанд бүрэн барагдах боломжтой байна.

Богино хугацаат өр төлбөрийн 30.3 сая төгрөг нь ажилчидтай холбоотой өглөг, 17.0 сая төгрөг нь татаас санхүүжилтийн өр төлбөр байна.

3.5.7 Цэвэр хөрөнгө, өмч

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 13,165.9 сая төгрөг байсан оны эцэст 14,639.6 сая төгрөг тайлант онд 1,473.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1,475.5 сая төгрөгийн ашигтай, өмнөх үеийн үр дүн рүү 1.5 сая төгрөгөөр залруулсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 5,925.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 5,925.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн төсвийг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17 өдрийн 06 тоот тогтоолоор 5,942.4 сая төгрөгөөр анх баталж өмнө оны болон тайлант оны орлого давсан холбоотойгоор 2021 онд 1 удаа тодотгол хийн 2021 оны 08 дугаар сарын 11-ны 02 тоот тогтоолоор нийт 6,143.5 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн тодотголыг сумын ИТХ-аар 2021 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 02 тоот тогтоолоор 6,143.5 сая төгрөгөөр 8 байгууллага, 2 сангийн төсвийг тодотгож баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 6,143.5 сая төгрөгийн төсөв баталснаас 4,374.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 1,105.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 470.7 сая төгрөгийг ОНХС-аас санхүүжих, 11.4 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 181.2 сая төгрөгийг туслах үйл ажиллагаанаас үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

	Хүснэгт 3: Төлөвлөгөө, гүйцэтгэл	
	Төлөвлөгөө	/сая. Төгрөг/ гүйцэтгэл
Улсын төсвөөс санхүүжих	4,374.7	4,189.4
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	4,374.7	4,189.4
Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,576.2	1,567.6
Орон нутгийн төсвөөс	1,105.5	1,096.9
Орон нутгийн хөгжлийн сан	470.7	470.7
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	192.6	255.2

Үндсэн үйл ажиллагааны орлогоос	11.4	10.2
Туслах үйл ажиллагааны орлогоос	181.2	245.0
ЭХ ҮҮСВЭРИЙН НИЙТ ДҮН	6,143.5	6,012.2

Эх сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,189.4, орон нутгийн төсвөөс 1,096.9, ОНХС-ийн санхүүжилт 470.7, үндсэн үйл ажиллагааны орлогоос 10.2, туслах үйл ажиллагааны орлогоос 255.2 сая төгрөг нийт 6,012.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 6,012.2 мянган төгрөгийг зарцуулж 185.3 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,551.1 сая мянган төгрөг буюу 98.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 0.5, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 0.9, бараа хангамж, бараа материалын зардал 0.2, нормативт зардал 2.1, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 0.5, бараа үйлчилгээний бусад зардал 0.5, хөрөнгийн зардал 52.1, буюу нийт 55.7 сая төгрөгөөр батлагдсан төсвийг хэмнэж зарцуулсан, эргэж төлөгдөх зээлийг 14.3 сая төгрөгөөр илүү олгосонтой холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.6, туслах үйл ажиллагааны орлого 150.4 сая төгрөгөөр тус тус батлагдаж гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.2, туслах үйл ажиллагааны орлогыг 174.9 сая төгрөгөөр нийт 175.1 сая төгрөгийн орлого бүрдүүлсэн. Нийт бүрдүүлсэн орлогын 134.7 сая төгрөгийг СХС, 37.8 сая төгрөгийг Булган хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн орлого, 2.4 сая төгрөг нь малжуулах төслийн эргэн төлөлт, 0.2 сая төгрөг нь сумын ЗДТГ-ын өөрийн орлого бүрдүүлэн 1.8 төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Булган сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 1/02 дугаар тогтоолд Булган сумын Төвлөрүүлэн захирагчийн тайлант онд 59.4 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 61.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 103 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 4. Сумын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төгрөг/

Орлогын ангилал	2021 оны		Зөрүү
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Татварын нийт орлогын дүн	303.2	375.3	(72.1)
Нийт орлого ба тусламжийн дүн	303.2	375.3	(72.1)
Татварын орлого	213.2	294.2	(81.0)
Орлогын албан татвар	11.0	12.4	18.3
Хувь хүний орлогын албан татвар	11.0	12.4	(1.4)
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	42.0	22.3	19.7
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	42.0	22.3	19.7
Хөрөнгийн албан татвар	113.7	148.5	(34.8)
Бууны албан татвар	3.7	3.4	0.3
Иргэдийн мөнгөн хадгаламжийн хүүгийн орлого	110.0	145.1	(35.1)
Малын тоо толгойн албан татвар	0.6	32.1	(31.5)
Малын тоо толгойн албан татвар	-	31.5	(31.5)
Ангийн орлого	0.6	0.6	-
Бусад татвар, телбер, хураамж	35.0	69.1	3.5
Бусад нийтлэг телбер, хураамж		37.6	(37.6)
Улсын тэмдэгтийн хураамж	17.0	27.8	(10.8)
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны	3.0	3.7	(0.7)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	15.0	0.0	15.0
Газрын телбер	1.1	1.2	(0.1)
Газрын телбер	1.1	1.2	(0.1)
Байгалийн нөөц ашигласны телбер	9.8	8.6	1.2

Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	2.5	0.1	2.4
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	7.3	8.5	(1.2)
Татварын бус орлого	90.0	81.1	8.9
Нийтлэг татварын бус орлого	90.0	81.1	8.9
Торгуулийн орлого	90.0	81.1	8.9

Эх сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт орлого 375.3 сая төгрөг буюу 72.1 сая төгрөгөөр давуулсан үүнээс татварын орлого 81.0 сая төгрөгөөр давсан, татварын бус орлого 8.9 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн байна. Орлого давсан шалтгаан нь хувь хүний орлогын татвар 1.4, малын тоо толгойн албан татвар 31.5, иргэдийн мөнгөн хадгаламжийн орлого 35.1, улсын тэмдэгтийн орлого 10.8, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны 0.7, бусад орлого 37.6, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр 1.2 сая төгрөгөөр тус тус давсан байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 19.7, хог хаягдлын үйлчилгээний хураамж 15.0, торгуулийн орлого 8.9 сая төгрөгөөр тасалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар аймгийн ОНХС-аас 56.1, Засаг даргын захирамжаар 11.5, БСУГ-аас ЕБС болон СӨБ-ийн байгууллагад ажиллаж байгаа багш нарын тэтгэмж 99.0, БСУГ-аас ковидын зардалд 5.6, стем хөтөлбөрийн санхүүжилт 21.2, бусад байгууллагын санхүүжилт 10.6, Статистикийн газраас судалгааны зардал 1.0, БОАЖЯ-аас хог хаягдлын хураамж 4.9, газрын дуудлагын худалдаа 1.0, туслах үйл ажиллагааны орлогоос 31.0 сая төгрөг нийт 241.9 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 224.8 сая төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 17.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай дараах асуудлууд байна. Үүнд:

1. Сум хөгжүүлэх сангаас 2011-2021 онуудад олгосон 211 зээлдэгчийн 962.7 сая төгрөгийн зээл олгогдсоноос 3 иргэн нас барсан, 118 зээлдэгч зээл бүрэн төлж дууссан, 41 иргэний 162.4 сая төгрөгийн зээлийн төлөх хугацаа болоогүй, 52 иргэний 135.3 сая төгрөгийн мянган төгрөгийн зээлийн авлага нь хугацаа хэтэрч байгаа нь сангийн хөрөнгийн эргэцийг удаашруулж, хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.
2. Малжуулах төсөл хөтөлбөрт 2012-2017 онд хамрагдсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад зээл олгохдоо гэрээ байгуулаагүй 35.4 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаа асуудал байна.

3.8 Аудитын гол асуудал

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд УТХО-оор 1,526.0 сая төгрөгийн өртөг бүхий Спорт цогцолборын барилга шинээр баригдсан, 200.0 сая төгрөгөөр 1 дүгээр цэцэрлэгийн барилгын их хийгдэж данс бүртгэлд тусгасан, ОНХС-ийн эх үүсвэрээр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажил, бэлтгэсэн үндсэн

хөрөнгүүд бүрэн нийлүүлэгдээгүйгээс авлага нэмэгдсэн асуудлууд үлэмж нөлөө үзүүлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн оруулаагүй, 30 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, батлагдсан төсөв, хагас жилийн санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүрээр мэдээлэх мэдээллийг огт оруулаагүй байна.

Аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангийн Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг мэдээлэх тусгай цэсгүйгээс тайлант онд орсон орлогын гүйлгээг мэдээлээгүй, зарлагын гүйлгээ гаргаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 151.3 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмж өгөгдөж хэрэгжилт бөгөөд 60 хувьтай, Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх талаар зөрчлийг арилгах албан шаардлага өгөгдөж хуульд заасан мэдээллийг байршуулаагүй хэрэгжилт хангадаагүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар өмнө оны давсан орлогоос хуваарилсан 131.0 сая төгрөгийг ОНХС-ийн дансаар дамжуулан Ковид-19 цар тахал, Шүлхий өвчинтэй холбоотой өрхийн эрүүл мэндийн төв, сумын Нэгдсэн эмнэлэгт оношлуур болон шатахууны зардлын зарцуулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажилтай холбоотой асуудлыг авч үзэх нь зүйтэй байна.

3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 9 төсвийн байгууллага, 2 тусгай сан, ОНӨҮГазар 1 нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагыг аудитад хамруулан дүгнэлт гаргаж, 6 тайланг түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй”-5 (Булган сумын 1,2 дугаар ЕБС, 1,2 дугаар Цэцэрлэг, Насан туршийн боловсрол), “Хязгаарлалттай” 1 (Минжит Булган спорт цогцолбор) нийт 6 дүгнэлт гаргасан байна.

Булган сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан төсвийн шууд захирагчдын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 180.3 сая төгрөгийн 28 алдаа зөрчил илэрч, 34.3 сая төгрөгийн 14 алдааг залруулсан байна.

Залруулагдаагүй 146.0 сая төгрөгийн алдаа зөрчлөөс 0.7 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 төлбөрийн акт тогтоон, 1.6 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгуулах 1 албан шаардлага өгч 143.7 сая төгрөгийн 11 алдаа зөрчилд зөвлөмж өгөгдсөн байна. Нийт алдаа зөрчил, шийдвэрлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт -5

/сая.төг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Булган сумын 1 дүгээр сургууль	5	22.1	4	22.1						1	
2	Булган сумын 2 дугаар сургууль	7	144.1	3	1.8	1	0.4				3	141.9
3	Булган сумын 1 дүгээр хүүхдийн цэцэрлэг	5	8.4	4	8.4						1	
4	Булган сумын 2 дугаар хүүхдийн цэцэрлэг	4	1.7	1	0.1						3	1.6
5	Булган сумын Минжит Булган 5 цагираг Спорт цогцолбор	3	1.8					1	1.6		2	0.2
6	Булган сумын Насан туршийн боловсролын төв	4	2.2	2	1.9	1	0.3				1	
	Дүн	28	180.3	14	34.3	2	0.7	1	1.6		11	143.7

Эх сурвалж: Булган сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

4. Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 827.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 233.5 сая төгрөгийн 7 алдааг залруулж, 0.8 сая төгрөгийн 1 алдаа зөрчилд төлбөрийн акт, 170.7 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 422.1 сая төгрөгийн 12 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Сангийн хөрөнгөөр стадионы засвар, цэнгэлдэх хүрээлэнгийн сандал, гэрэлтүүлэг, хашаа, Нэгдсэн эмнэлэг, Хүүхдийн цэцэрлэгт нийлүүлэх тоног төхөөрөмжийг хүлээн аваагүй 112.8 сая төгрөгийг шууд зардлаар бүртгэж авлагаар тусгаагүй,
2. ТТЗ-ийн санхүүгийн тайланд Спорт цогцолборын тайлант хугацааны хуримтлагдсан элэгдлийн зардлыг э-тайлангийн цахим системд нэгтгэхдээ 1.8 сая төгрөгөөр бусдаар зардлаар хүлээн зөвшөөрсөн,
3. Хот тохижилтын санхүүгийн тайланд 6.1 сая төгрөгөөр бусад тооцооны өглөг, ХХОАТ-ын авлага, өглөгийг,
4. ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд тайлант үеийн үр дүнг 112.8 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг тус тус залрууллаа.

Шийдвэрлэсэн нь: Шалгагдагч байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан 233.5 сая төгрөгийн залруулга хийсэн болно.

4.2 Төлбөрийн акт

1. Засаг даргын Тамгын газрын даргад ажил хавсран ажилласны нэмэгдэл олгосон холбогдох шийдвэргүй, томилолтын хуудасгүй албан томилолтын зардалд 0.8 сая төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.3. "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 20.2.5-д дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.2.

“Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

4.3.1 1 Илрүүлэлт: СХС-ийн хөрөнгөөс зээлдэгчийн нар зээлийн гэрээний үүргээ биелүүлээгүй 51 зээлдэгчтэй холбоотой 135.3 сая төгрөгийн зээл, зээлийн хүүгийн хугацаа хэтэрсэн үлдэгдэлтэй, Малжуулах төслийн 2013- 2017 онд төсөлд хамруулан зээл олгохдоо гэрээ байгуулаагүй, төсөлд хамрагдсан зарим иргэд өнөөг хүртэл зээлээ төлөөгүй 16 иргэнтэй холбоотой 35.4 сая төгрөг нийт 170.7 сая төгрөгийн авлага барагдуулаагүй сангийн дансанд төвлөрүүлээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Зээлдэгчтэй байгуулсан гэрээний 7.2.4-д "Зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлнэ", 8.2-д "Зээлдэгч зээлийн төлбөрийг сар бүрийн төлбөрийн хуваарийн дагуу төлнө", 9.2-д "Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй дараах тохиолдолд Зээлдүүлэгч гэрээг цуцалж, зээл, хүү нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг үл маргах журмаар төлүүлнэ. Үүнд: 9.2.1-д "Зээлийн гэрээний 3.2-т зааснаас өөр зориулалтаар ашигласан", 9.2.2-д "Зээлийн гэрээгээр тохиролцсон хуваарийн дагуу төлбөрөө бүрэн төлөлгүй 60 хоног хугацаа хэтэрсэн", 9.2.4-д "Гэрээгээр хүлээсэн үүргээ 2-оос дээш удаа зөрчсөн, эсвэл 15 дээш хоногоор хугацаа хэтрүүлсэн бол", гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

4.3.2 Илрүүлэлт: Шилэн дансны хуульд заасны дагуу батлагдсан төсөв, хагас жилийн санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүрээр, 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баланс, аудитын тайлан дүгнэлт, аудитын мөрөөр хэрэгжүүлсэн ажлын тайлан болон бусад мэдээллийг shilendans.gov.mn цахим сайтад холбогдох мэдээллийг оруулаагүй хоосон илгээсэн, мэдээлэл огт оруулдаггүй зөрчил илэрсэн нь Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 29 дүгээр тогтоолын холбогдох заалтуудыг мөрдөөн ажиллаагүй, өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцуулах албан шаардлага өгөв.

4.4. Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 **Авлагатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: -ЗДТГ-ын санхүүгийн тайланд 5.0 сая төгрөгийн авлага нь он дамжсан насжилт өндөртэй, эзэн холбогдогч нь тодорхой бус барагдуулаагүй ог дамжин бүртгэгдэж байгаа нь төсвийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Сум хөгжүүлэх сангаас олгох зээл, барьцааны гэрээний 2.3-д "Зээл, хүүгийн эргэн төлөх хуваарь"-ийн дагуу төлөгдөөгүй зээлд хоног тутамд ногдох хүүгийн 0.05 хувьтай тэнцүү байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж Авлага барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулан авлагыг барагдуулж ажиллах

4.4.2 **Бараа материалын тайлан, тооллоготой холбоотой асуудал**

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгөнөөс бараа материал худалдан авч бэлтгэхдээ нярав орлого аваагүй байна. Мөн бараа материалын тооллогын үлдэгдлийг баталгаажуулж баримтжуулж, хяналт тавин үнэн зөв бодитой тооллого хийх шаардлагатай байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах" 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1.3-д "аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна", 1.5-д "... Журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам" тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэсэн заалтуудыг мөрдөөгүйтэй холбоотой байна.

Өгсөн зөвлөмж Бараа материал худалдан авсан тухай бүрд нярваар орлого авхуулж, зарлагагдахдаа нярав нь албан хаагчдаар шаардах хуудас бүрэн бичүүлж дарга, нягтлан бодогчоор хянуулж зөвшөөрсөн тохиолдолд олгож хэвших, Бараа материалын тооллогыг үнэн зөв бүрэн хэрэгжүүлэх

4.4.3 ***Ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал***

Илрүүлэлт: Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, төсөвт төвлөрүүлээгүй 48.8 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасан заалтыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

Зөвлөмж: Төсвийн тухай хуулийн төсвийг хэмнэлттэй зарцуулах талаар анхааран ажиллах

4.4.4 ***Шатахууны зарцуулалттай холбоотой асуудал***

Илрүүлэлт: Албан ажлын хэрэгцээнд ажилтан албан хаагчдын хувийн унаанд шатахуун олгож зарцуулсан, ЗДТГ-ын Ланд 200, тоёото, Приүс 30 маркийн суудлын автомашинуудад шатахуун, түлш олгон зарцуулсан ч явсан ажлын тайланг хавсаргаагүй, жолоочийн тооцоог үнэн зөв бодож хянаагүй зөрчил байна.

Зөвлөмж: Жолоочийн тооцоог үнэн зөв бодож зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллах

4.4.5 ***Шилэн данстай холбоотой асуудал***

Илрүүлэлт: Минжит булган ОНӨААТҮГ нь Шилэн дансны цахим системд оруулбал зохих мэдээллийг оруулахдаа иж бүрэн, үнэн зөв мэдээлээгүй, Соёлын төв нь Шилэн дансны хуульд заасны дагуу цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлогын 106.2 сая төгрөгийн санхүүжилтийн ажил гүйлгээг мэдээлээгүй байгаа нь *Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмыг зөрчсөн байна.*

Өгсөн зөвлөмж: Хууль, журамд заасны дагуу Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган холбогдох мэдээллийг үнэн мэдээлж хэвших

4.4.6 **Орон тоотой холбоотой асуудал**

Илрүүлэлт: Соёлын төв нь тайлант онд батлагдаагүй орон тоонд ажил хавсран ажилласны нэмэгдэлд 1.6 сая төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.9-д “дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох” гэсэн заалттай нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдаагүй орон тоонд нэмэгдэл цалин олгохгүй байх

4.4.7 **Төсвийн гүйцэтгэл, төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Сумын төсөвт байгууллагын дүнгээр тогтмол зардлыг 308.4 сая төгрөгөөр төлөвлөж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан 303.9 сая төгрөгөөр, Төрийн сангийн зарлагын хуулгаар 282.5 сая төгрөгийн зардал гаргаж 21.4 сая төгрөгийг бусад бараа үйлчилгээний зардал гүйлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7-д “энэ хуулийн 22.2-т заасан төсвийн ангиллын төрөл бүрээр дэлгэрэнгүй ангилал тогтоох, түүнийг төсвийн төлөвлөлт, тайлагналт, гүйцэтгэлд ашиглах журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно”, 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг мөрдөн ажиллах заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн ангиллын дагуу төсөвт журмын дагуу зохицуулалт хийж зардлыг санхүүжүүлэн, Төсвийн гүйцэтгэлийн тайланг үнэн зөв илэрхийлж тайлагнах

4.4.8 **Зээлдэгчтэй байгуулсан гэрээтэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Сум хөгжүүлэх сангаас зээлдэгчтэй байгуулсан гэрээнд заасан СХС-аас олгох зээлийн гэрээнд заасны дагуу алданги тооцоогүй зөрчил илэрлээ. Энэ нь сум хөгжүүлэх сангаас олгох барьцаат зээлийн гэрээний Сум хөгжүүлэх сангаас олгох зээл, барьцааны гэрээний 2.3-д “Зээл, хүүгийн эргэн төлөх хуваарь”-ийн дагуу төлөгдөөгүй зээлд хоног тутамд ногдох хүүгийн 0.5 хувьтай тэнцүү байна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж : Гэрээнд заасны дагуу алданги тооцон, СХС-ийн программд мэдээллийг үнэн зөв оруулж хэвших

4.4.9 **Төсвийн төлөвлөлт, зарцуулалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: ИТХурал нь 2.6 сая төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтын бүрдүүлэлтгүй томилолтын болон ГХУСАХЗардлын ажил гүйлгээ гаргасан зэрэг илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудын хэрэгжилт хангагдаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримт дутуу ажил гүйлгээг санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоох

4.4.10 **Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Булган сумын Минжит Булган хот тохижуулах газрын дарга тайлант 2 удаа нягтлан бодогч 3 удаа солигдсон, цалин, ХХОАТ-ын өглөг авлагатай холбоотой

тооцоо нийлээгүй, дансны хуулгыг үндэслэн мөнгөн гүйлгээний орлого зарлагын журналыг бүрэн боловсруулаагүй, НББ-ийн хөтлөлт хангалтгүй байна. Мөн бараа материалыг орлогод аваагүй, зарлагадахдаа эд хариуцагч нь шаардах хуудсыг бүрэн бичүүлээгүй дарга, нягтлан бодогчоор хянуулж, гарын үсэг зуруулж баталгаажуулаагүй, бараа материалын үлдэгдэлд тооллого хийж тооцоо нийлж тооцоо бодоогүй, дотоод хяналт сул байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 20 дугаар зүйлийн 20.2.5. “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Нийгмийн даатгалын багц хуулийн 32 дугаар зүйлийн “Нийгмийн даатгалын шимтгэл ногдуулах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: *Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааг тогтвортой явуулах, санхүү нягтлан бодох бүртгэлийн удирдлага арга зүйгээр хангаж тогтвортой ажиллуулан зөрчлийг арилгуулах*

4.4.11 Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын шатахууны зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хогны машин 2, бохирын машин 1, Ковш 1, Комбайн 1 нийт үйл ажиллагаандаа ЗДТГ-ын данс бүртгэлд бүртгэлтэй нийт 5 авто машин үйл ажиллагаандаа ашиглаж байгаа ч жолоочийн замын хуудас, жолоочийн тооцоог бүрэн бодоогүй, бэлтгэн нийлүүлэгчээс бараа материал худалдан авахдаа төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсвэл цахимаар илгээх үүрэгтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудыг мөрдөөгүй.

Зөвлөмж: Холбогдох хуульд заасны дагуу худалдан авалтыг и баримтаар баталгаажуулаагүй ажил гүйлгээг гаргахгүй байх,

4.4.12 Сумын засаг даргын дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: ОНХС-аас Ковид-19 цар тахал, малын шүлхий өвчний онцгой байдлын үйл ажиллагааны зардалд өмнөх оны давсан орлогоос 131.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, онцгой байдлын үйл ажиллагааны шатахуун болон оношлуур, эмнэлгийн 1 удаагийн хэрэгслийг худалдан авахад 118.8 сая төгрөгийг зарцуулж, дотоод хяналт хэрэгжүүлээгүй, хэчнээн нэр төрлийн материал авч хэнд хүлээн өгсөн нь тодорхой бус, сумын ТТЗ-ын нэгтгэлд хамрагдсан байгууллагуудын санхүүгийн тайланд тусгасан тоо мэдээлэл нь зөрүүтэй, сумаас байгууллагын дотоод хяналт хэрэгжээгүй, санхүүгийн ил тод мэдээлэл хангагдаагүй, зөрчлийн нэгтгэлд дурдсан болон анхаарах хандуулахуйц асуудлын хэсэгт бичсэн алдаа зөрчилд дахин хяналт, шалгалт хийх шаардлагатай байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна, Төсвийн тухай хуулийн 16.5.6 -д “Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Засгийн газрын 311 дүгээр тогтоолын 1.5-д “энэ журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө”, 3.5-д “дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд 1 доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж,

шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ”, 3.6-д ”дотоод хяналт

Булган сумын ТТЗ-ын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Зөвлөмж: Сумын Засаг даргын захирамжаар дотоод хяналтын баг томилон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлэн ажиллах, Онцгой байдлын үйл ажиллагаанд зарцуулсан бараа материалын зарцуулалтын тооцоог дахин бодох,

4.4.13 Орлого бүрдүүлэлт, батлахтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд сумын татварын орлогыг бодитой төлөвлөөгүйгээс малын тоо толгойн албан татварын орлогыг төлөвлөөгүй **31.5** сая төгрөгийн орлого бүрдүүлсэн нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6.2-д "албан татварын хэмжээг энэ хуулийн 6.1-д заасан хязгаарт багтаан сум, дүүргийн ИТХ малын төрөл тус бүрээр тогтооно", Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8-д "Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ:", 23.8.15-д "малын тоо толгойн албан татвар" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаагүй байна.

Зөвлөмж: Татварын болон татварын бус орлогыг бодит төлөвлөж, сумын ИТХ-аар батлуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дүгээр сарын 03-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. ТТЗ-ын тайлангаар болон түүврийн байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	байгууллагын нэр	Хүснэгт – 6		/сая. төгрөгөөр/							
		Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
		Тоо	Дүн	Запруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган ТТЗ	7	321.7	2	114.6			1	35.4	4	171.7
2	Булган ЗДТГ	6	140.8	1	-	1	0.8			4	140.0
3	Булган ИТХ	1	2.6							1	2.6
4	Булган сумын Соёлын төв	2	107.8							2	107.8
5	Булган сумын ОНХС	1	112.8	1	112.8						
6	Булган сумын СХС	1	135.3					1	135.3		
7	Булган сумын Минжит Булган хот тохижилт ОНӨҮГ	5	6.1	3	6.1					2	
	Дүн	23	827.1	7	233.5	1	0.8	2	170.7	13	422.1

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:  Д.НАРАНТУУЛ

АХЛАХ АУДИТОР:  Д.НАРАНТУУЛ

Аудитын код: ХОА-2022/02/НА-СТА-ТТЗ

28

